



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26 74 68, И-мэйл: info@mof.gov.mn
Вэбсайт: www.mof.gov.mn

2023.04.06 № 03/2040
танай _____-ны № _____-т

Гомдол хянасан тухай

Танай байгууллагаас зарласан ЭНЭҮТ2/202301014 дугаартай “Эмнэлгийн тавилга /ширээ, сандал” нийлүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтад оролцсон “Био реагент” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 55 дугаар зүйлийн 55.2 дахь хэсэг болон Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар баталсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу захиалагчаас ирүүлсэн холбогдох баримт материалд үндэслэн хянан үзлээ.

“Био реагент” ХХК-ийн гомдолд хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 27.4, 28 дугаар зүйлийн 28.4.5 дахь заалтыг үндэслэн тус компанийн тендерээс татгалзсан захиалагчийн шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй байх тул хянан үзэхийг хүссэн байна.

Захиалагчаас “Био реагент” ХХК-д хүргүүлсэн мэдэгдэлд хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.3, 27.4, 28 дугаар зүйлийн 28.4.5 дахь заалтад заасан шаардлага хангахгүй гэж тус компанийн тендерээс татгалзсан нь хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “Захиалагч тендер нээснээс хойш ажлын 15 өдрийн дотор ... тендерт оролцогч бүрд шалгараагүй үндэслэлийн хамт нэгэн зэрэг бичгээр мэдэгдэнэ” гэж заасанд нийцэхгүй байна.

Үнэлгээний хорооны дүгнэлтээс үзэхэд “Био реагент” ХХК-ийн ирүүлсэн тендер тендерийн баримт бичигт заасан ямар шалгуур үзүүлэлтийг хангахгүй учраас хуулийн дээрх заалтуудад нийцэхгүй гэж хянан үзсэн нь тодорхойгүй байна.

Иймд захиалагчийн 2023 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн 02/166 тоот гэрээ байгуулах эрх олгосон шийдвэр болон 02/167 тоот мэдэгдлийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.1 дэх заалтыг үндэслэн хүчингүй болгон шийдвэрлэж байна.

Тендер шалгаруулалтын үнэлгээг хууль, журамд нийцүүлэн дахин хийхийг хуулийн 55 дугаар зүйлийн 55.3.3 дахь заалтад үндэслэн мэдэгдье.

Хуулийн 55 дугаар зүйлийн 55.4 дэх хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түр түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Био реагент” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



Ж.ГАНБАТ